

Аудит хийх үндэслэл, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Төв аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн дагуу хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: МСҮТ-үүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн ч тэтгэлэг олголтод тавих хяналт хангалтгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан



**Зуунмод
2016 он**

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар..... 3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4
	Аудитын дүн.....5
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	БҮЛЭГ -1 Дүгнэлт <i>МБСДСангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд хууль дүрэм журмууд нь сангийн үйл ажиллагааг зохицуулж бусад хуультай нийцэж байна.....5</i>
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ- 2 Дүгнэлт <i>Төв аймагт МБСДСан байдаггүй тул эх үүсвэрийг төлөвлөх , бүрдүүлэх шаардлагагүй, харин аймагт байрлах 5 МСҮТ-д хувьсах зардал болон суралцагчид тэтгэлэг олгох санхүүжилт олгосон байна.....6</i>
Ахлах аудитор Ц.Саранчимэг Д.Пүрэвсүрэн	БҮЛЭГ- 3 Дүгнэлт <i>Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож буй хувьсах зардал, тэтгэлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....7</i>
2016 оны 10 дугаар сарын 9	БҮЛЭГ- 4 Дүгнэлт <i>МСҮТ-үүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн ч тэтгэлэгтэй холбоотой зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.....10</i>
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/	Дүгнэлт.....13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	Зөвлөмж.....14
ХАЯГ:	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал15
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
АОУС	Аудитын оон улсын стандарт
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
МУЗГ	Монгол улсын засгийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Төв аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”, “Байгаль орчныг хамгаалах сан”-гийн үйл ажиллагаа, эдгээр сангаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын дагуу аудит хийлээ.Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ: Аудитад аймгийн Зуунмод, Заамар, Баянчандмань, Эрдэнэ, Батсүмбэр суманд байрлах Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд зэрэг байгууллагууд хамрагдсан.

Аудитын арга зүй: Аудитыг АОУС 4100, 4200, гүйцэтгэлийн аудитын гарын авлагыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

1. Төрийн аудитын тухай хууль
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
3. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
4. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам
5. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
6. Төсвийн тухай хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
9. Шилэн дансны тухай хууль
10. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн Аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Ц.Саранчимэг, Аудитор Д.Пүрэвсүрэн, нар 2016 оны 08-р сарын 31-нээс 10-р сарын 09-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Бүлэг 1

МБСДСангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд хууль дүрэм журмууд нь сангийн үйл ажиллагааг зохицуулж бусад хуультай нийцэж байна.

1.1 Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн үү?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Боловсролын тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журамуудаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.2 Хууль дүрэм журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадаж байна уу?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг хууль, дүрэм, журмуудаар бүрэн зохицуулагдаж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн талаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.24-д Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан гэсэн тусгай сан байна. Энэ нь тусгай сангийн ангилалаар 6.1.1-д тусгай хуулиар зохицуулах сан гэж заасан байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн тав дугаар бүлгийн 21-24 дүгээр заалтаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын санхүүжилт, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв, орлогын эх үүсвэр, зарцуулалт болон Боловсролын тухай хуулийн 43.2, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 17.1.4-ийг үндэслэн Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 117 тоот тогтоол, 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 477 тоот тогтоолуудаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

1.3 Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байна уу?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм журмууд нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулж буй Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Боловсролын тухай хуулиудыг үндэслэн гаргасан Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох тухай журмууд нь хууль тогтоомжтой нийцэж байна.

Бүлэг 2

МБСДСан Төв аймагт байдаггүй тул эх үүсвэрийг төлөвлөх, бүрдүүлэх шаардлагагүй, харин аймагт байрлах 5 МСҮТ-д хувьсах зардал болон суралцагчид тэтгэлэг олгох санхүүжилт олгосон байна.

2.1 Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна уу?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан аймагт байхгүй учраас орлого төлөвлөгдөөгүй байна.

МБСДСангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22.1-д улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллагаас мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зорилгоор олгосон зээлийн хөрөнгө, буцалтгүй тусламж, гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж, аж ахуйн нэгж, байгууллагаас энэ хуулийн 20.3-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө, бусад эх үүсвэр гэж заасан байна.

Төв аймагт мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байдаггүй Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24.2-д Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална гэсэн заалт байгаа боловч орон нутгийн төсвийн төсөл боловсруулах, Сангийн ямаар хянуулах батлуулах явцад энэ санд хөрөнгө төлөвлөх, батлуулах асуудал хөндөгдөлгүй явж иржээ.

2.2 Сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн үү?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан байдаггүй учраас орлого бүрдүүлээгүй, харин ирсэн санхүүжилт зориулалтын дагуу хувиарлагдсан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан гэж манай аймагт байдаггүй тул бүрдүүлсэн орлого гэж байхгүй. Харин тус сангаас 2015-2016 онд Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ-дэд нэг сурагчидад ногдох хувьсах зардал, Эрдэнэ, Заамар, Баянчандмань, Зуунмод, Батсүмбэр суман дахь МСҮТ-д 24 хүртэлх насны суралцагчдад олгох тэтгэлэг хувиарлагдсан байна.

Бүлэг 3

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож буй хувьсах зардал, тэтгэлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.1 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна уу?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлсэн хувьсах зардал, тэтгэлэг хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 5.1-д Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино гэж заасан байна.

Энэхүү зорилго, зорилтын хүрээнд мөн хуулийн 17.1.4-д Засгийн газраас тогтоосон журмын дагуу Боловсролын тухай хуулийн 43.2-т заасан нийгмийн баталгаагаар хангагдах гэсний дагуу суралцагч тэтгэлэг авах эрх үүссэн байна.



Оюутнуудын амжилттай суралцах эрмэлзлэлийг дэмжин идэвхи чармайлтыг дээшлүүлэх, амжилтыг нь урамшуулах зорилгоор Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 477 тоот тогтоолоор батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журмын 1.1-д Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгоход энэхүү журмыг баримтална, 1.2-д Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2.5 жил, техникийн боловсролын 1.5 болон 3 жилийн сургалтад хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчид тэтгэлэг олгоно гэж заасны дагуу улсын дөрвөн МСҮТ, хувийн нэг МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгосон байна. 2015-2016 онд нийт тэтгэлэг хамрагдсан суралцагчийн тоог дараах хүснэгтээр харууллаа.

	Аймаг, нийслэл	Нийт суралцагчийн тоо		Нийт тэтгэлэг хамрагдсан суралцагчийн тоо		Нийт тэтгэлэг хамрагдсан хувь	
		2014-2015	2015-2016	2014-2015	2015-2016	2014-2015	2015-2016
1	Төв Батсүмбэр	161	161	30	30	18.6	18.6
2	Төв Баянчандмань	420	513	352	359	83.8	70.0
3	Төв Эрдэнэ	315	284	289	209	91.7	73.6
4	Төв Заамар	191	191	111	78	58.1	40.8
5	Төв Зуунмод	351	378	284	172	80.9	45.5
	Төв аймаг	1438	1527	1066	848	74.1	55.5

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.12-д өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгох гэсэн заалтыг үндэслэн МУЗГазраас 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 94 тоот тогтоолын 1-д Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баталсан байна. Энэхүү тогтоолын дагуу “Шинэ Батсүмбэр сум” төслийн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу байгуулагдсан Төв аймгийн Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ-д 2015 онд 17178.8 мянган төгрөг, 2016 онд 95288.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын явцад Төв аймгийн Зуунмод МСҮТ, Баянчандмань МСҮТ, Эрдэнэ МСҮТ, Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ зэрэг дөрвөн суманд очин сургуулийн сургалтын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, объект дээрх үе шатны ажлын горимуудыг хэрэгжүүлж ажилласан. Зарим сургуулиуд суралцагчидын ангийн журналаа хөтлөж эхлээгүй, ирцийн бүртгэлийг албан ёсны маягтаар хөтлөөгүй зэрэг алдаа зөрчилтэй байсан.

3.2 Төсөл хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулсан уу?

Орон нутагт ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулалт хийгдэх төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас нэг суралцагчид олгох хувьсах зардал болон 24 нас хүртэлх суралцагчидад тэтгэлэг олгох зардал батлагдаж санхүүжилт олгогдсноос өөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй тул ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулалт хийгдэх шаардлагагүй байна.

3.3 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан уу?

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулалт хийгдэх төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй тул гэрээ байгуулах шаардлага гараагүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас нэг суралцагчид олгох хувьсах зардал болон 24 нас хүртэлх суралцагчидад тэтгэлэг олгох зардал батлагдаж санхүүжилт олгогдсноос өөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно.

3.4 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн үү?

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас 2014-2015 онд 1066 суралцагч, 2015-2016 онд 848 суралцагч тэтгэлэгт хамрагдаж, 2014-2015 онд 478, 2015-2016 онд 665 мэргэжилтэй ажилтан бэлтгэгдсэн байна.

МБСДСангаас санхүүжүүлсэн тэтгэлэгийн зардлаар Төв аймагт байрлах Мэргэжил сургалт, үйлдвэрлэл төвийн суралцагчидад 2015-2016 онд сар бүрийн давхардсан тоогоор нийт 14374 суралцагч 843020.2 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоос 675526.7 мянган төгрөгийн тэтгэлэг авч 167493.5 мянган төгрөгийн тэтгэлэг дутуу олгосон бөгөөд энэ нь 2016 оны 3.4.5.6-р саруудын тэтгэлэг олгогдоогүй байгаатай холбоотой байна.

Он	Аймаг, нийслэл	Тэтгэлэг авсан							
		Нийт сурагчдийн тоо					Олговол зохих тэтгэлэгийн дүн /мян.төг/	Олгосон тэтгэлэгийн дүн /мян.төг/	Авлага /мян.төг/
		1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	Нийт			
2015	Төв Майндсет МСҮТ	90	0	0	0	0	6149.5	0.0	6149.5
	Төв Баянчандмань МСҮТ	2135	1440	619	0	4213	222794.4	129535.8	93258.6
	Төв Эрдэнэ МСҮТ	1291	857	373	0	2509	146215.2	92721.4	53493.8
	Төв Заамар МСҮТ	321	259	346	0	926	51179.7	30472.6	20707.1
	Төв Зуунмод МСҮТ	995	780	310	0	2085	139206.0	82257.4	56948.6
	Төв аймгийн дүн	4832	3336	1498	0	9733	565544.8	334987.2	230557.5
2016 оны эхний хагас жилд	Төв Майндсет МСҮТ	150	0	0	0	0	9901.5	9576.0	325.5
	Төв Баянчандмань МСҮТ	1230	962	124	0	2316	111378.0	136442.7	-25064.7
	Төв Эрдэнэ МСҮТ	640	395	0	0	1031	71277.7	84041.0	-12763.3
	Төв Заамар МСҮТ	144	132	111	0	387	26917.8	31103.5	-4185.7
	Төв Зуунмод МСҮТ	561	346	0	0	907	58000.4	79376.2	-21375.8
	Төв аймгийн дүн	2725	1835	235	0	4641	277475.4	340539.5	-63064.0
Төв аймгийн дүн		7557	5171	1733	0	14374	843020.2	675526.7	167493.5

МБСДСангаас суралцагчид олгох тэтгэлэг 2015 онд МСҮТ-д тэтгэлэгийн санхүүжилтээр сургуулийн харилцах дансанд ордог байсан бол 2016 оноос сургуулиудаас суралцагчийн тэтгэлэгийн тооцоог сар бүр нэхэмжлэн суралцагчийн хувийн данс руу шууд шилжүүлдэг болсон байна. Иймд 2016 оны хувьд МСҮТөвүүдийн санхүүгийн тайлан болон баримтаас тэтгэлэг олголтыг нарийвчлан шалгах боломж хязгаарлагдмал байна.

Мэргэжлийн өндөр ур чадвартай, авъяас чадавхийг хөгжүүлж, асуудлыг шийдвэрлэх, бүтээлчээр ажиллахад нь шаардагдах чанартай боловсрол, мэргэжил эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн салбар, аж ахуйн нэгж байгууллагад ажиллах ур чадвартай ажилтан бэлтгэх зорилго, зорилтын хүрээнд 2014-2015 он, 2015-2016 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 43-45 мэргэжлээр 1707-1758 суралцагч суралцаж, 848-1066 суралцагч тэтгэлэгт хамрагдаж , 2014-2015 онд 478, 2015-2016 онд 665 мэргэжилтэй ажилтан бэлтгэгдсэн байна.

№	Аймаг, нийслэл	Мэргэжил		Нийт суралцагчийн тоо		Тэтгэлэг хамрагдсан суралцагчийн тоо		Төгсөгчдийн тоо	
		2014-2015	2015-2016	2014-2015	2015-2016	2014-2015	2015-2016	2014-2015	2015-2016
1	Төв Батсүмбэр МСҮТ	4	4	161	161	30	30		
2	Төв Баянчандмань МСҮТ	12	10	538	513	352	359	125	151
3	Төв Эрдэнэ МСҮТ	9	10	407	405	289	209	168	172
4	Төв Заамар МСҮТ	9	10	250	301	111	78	107	138
5	Төв Зуунмод МСҮТ	9	11	351	378	284	172	78	204
	Төв аймаг	43	45	1707	1758	1066	848	478	665

Бүлэг 4

МСҮТ-үүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн ч тэтгэлэгтэй холбоотой зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.

4.1 Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн үү?

4.1 Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож буй хувьсах зардал болон тэтгэлэгийн зарцуулалтанд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн дэргэдэх дотоод хяналтын нэгжээс шалгах эрх нээлттэй байдаг. МСҮТ-үүд нь дотоод хяналтын нэгж, хяналт шинжилгээний ажилтантай бөгөөд сургалтын үйл ажиллагаа, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нээлттэй ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт хийх төлөвлөгөөтэй, түүний хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

Гэхдээ 2015 оны хувьд санхүүжилт хэлбэрээр МБСДСангаас хувьсах зардал, тэтгэлэг дансаар орж байсан бол 2016 оноос тэтгэлэг нь МБСДСангаас суралцагчийн дансанд шууд шилжүүлдэг болсон тул дотоод хяналт тавих боломж хумигдсан байна.

4.2 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдэж байна уу?

МСҮТ-үүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн ч тэтгэлэгтэй холбоотой зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.

МБСДСангаас олгож буй тэтгэлэгийн зарцуулалтанд дотоод хяналт шалгалт аймгийн МСҮТ-үүдэд хийгдэж байгаагүй байна. Иймээс Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг олгох журмын 2.2.1-д мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ын дагуу элссэн байх, 2.2.2-д хүндэтгэн үзэх шалтгаантайгаас (эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт) бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх гэсэн шаардлага ерөнхий нөхцлийг хангасан эсэхэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн журмын 1.2-д Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2.5 жил, техникийн боловсролын 1.5 болон 3 жилийн сургалтад хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчид тэтгэлэг олгоно гэсэн нийтлэг үндэслэлд тавих дотоод хяналт сул байгаагаас нийт МСҮТ-үүдэд суралцагчидад олгож буй тэтгэлэгтэй холбоотой зарим зөрчил гарч байна. Үүнд:

- Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ-ийн 2015 оны 10-р сард сургалт эхлээгүй байхад 30 суралцагчийн 2072.0 мянган төгрөгийн тэтгэлэгийг илүү нэхэмжилж авсан байна.
- 2015-2016 оны суралцагчид олгосон тэтгэлэгийг шалгахад анги удирдсан багш, сургалтын менежер, захирал нарын тэтгэлэг авч буй суралцагчдийн регистр, ирцийн бүртгэлд тавих хяналт сул байгаагаас шалтгаалан 24-н наснаас дээш насны суралцагчид Баянчандмань МСҮТ 1748.3 мянган төгрөг, Эрдэнэ МСҮТ 744.2 мянган төгрөг, Заамар МСҮТ 155.3 мянган төгрөг, Төв Зуунмод МСҮТ 863.3 мянган төгрөгийн нийт 3511.4 мянган төгрөгийн тэтгэлэг илүү олгосон байна.
- Төв Зуунмод МСҮТ, Эрдэнэ сумын МСҮТ-ийн суралцагчид олгосон тэтгэлэгийн тооцоо, ангийн журнал дээрх ирцийн бүртгэлийг тулган шалгахад зөрүүтэй байна. Энэ нь сургалтын албанаас багш нарын журнал хөтлөлт ирцийн бүртгэлд тавих хяналт сул, зарим багш нар сурагчийн ирцийн бүртгэлийг нэгтгэхдээ хичээл таслалтыг үнэн зөв гаргаагүйтэй холбоотой байна.
- Төв Зуунмод МСҮТ, Заамар МСҮТ нь Хөдөлмөрийн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/197 тоот тушаалаар батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журмын 3.2-д Мэргэжлийн боловсрол олгох сургалтад суурь боловсролтой иргэнийг элсүүлнэ гэж заасан байхад суурь боловсролын гэрчилгээгүй, ерөнхий боловсролын сургуулийн албан бус боловсролд бүртгэлтэй суралцагчийг бүртгэн суралцуулж дээрх шийдвэрийг зөрчсөн байна.

Дээр дурьдсан алдаа зөрчилд нийт 5583.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 21 ажилтанд хариуцлага тооцуулах албан шаардлага бичигдлээ.

4.3 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байна уу?

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамааралтай Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ бөгөөд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдоогүй

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэсэн заалтын дагуу Зуунмод, Баянчандмань, Эрдэнэ, Заамар сумдын МСҮТ шилэн дансны нэгдсэн цахим сүлжээнд бүрэн хамрагдаж, байгууллага түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан нарын нэр, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээлэлийг оруулсан байна.

Гэхдээ Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 1.3-д байгууллага нь мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалан, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байна гэснийг хэрэгжүүлэлгүй Заамар МСҮТ, Төв МСҮТ-ийн захирал 2016 оны 4-р сард томилогдсон байхад өнөөдрийг хүртэл ерөнхий менежерийн овог нэр холбоо барих утасыг шинэчилж оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд хамаарна гэж заасан байна. Үүнд хамааралтай байгууллага нь Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ бөгөөд шилэн дансны цахим хуудсанд холбогдоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамааралтай дээрх байгууллагууд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 6.1.2-д төсвийн гүйцэтгэлийг сар, улирлын дараа сарын 08-нй дотор, 6.1.6-д төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгааны тайлбарыг улирал бүр тогтмол мэдээлнэ гэж заасан тогтмол байршуулах мэдээллийг тухай бүр мэдээлж мөн хуулийн 6.4-д заасан 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг тухай бүрд тавьж мэдээллийг ил тод нээлттэйгээр ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✓ МБСДСангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд хууль дүрэм журмууд нь сангийн үйл ажиллагааг зохицуулж бусад хуультай нийцэж байна.
- ✓ Төв аймагт МБСДСан байдаггүй тул эх үүсвэрийг төлөвлөх, бүрдүүлэх шаардлагагүй, харин аймагт байрлах таван МСҮТ-д хувьсах зардал болон суралцагчид тэтгэлэг олгох санхүүжилт олгосон байна.
- ✓ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож буй хувьсах зардал, тэтгэлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- ✓ Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн ч тэтгэлэгтэй холбоотой зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.
- ✓ Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд суралцагчийн журналд ирцийн бүртгэл хөтлөлтийг бүрэн хийгээгүй, ирцийн сар бүр нэгтгэж гаргаагүй, ирцийн бүртгэлээс зөрүүтэйгээр тэтгэлэгийн тооцоог хийж байна.
- ✓ Мэргэжлийн боловсрол олгох сургалтад суурь боловсролтой иргэнийг элсүүлэх журмыг зөрчин суурь боловсролын гэрчилгээгүй, ерөнхий боловсролын сургуулийн албан бус боловсролд бүртгэлтэй суралцагчийг бүртгэн суралцуулсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал нарт зөвлөх нь:

1. Суралцагчдид хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх гэсэн шаардлага ерөнхий нөхцлийг хангасан эсэхийг хянахдаа журналын ирцийн бүртгэл, хөтлөлтөнд анги удирдсан багш, сургалтын менежерүүдийн тавих хяналтыг тогтмолжуулж сайжруулах.
2. Суралцагчид олгох тэтгэлэгийн тооцоог ирцийн бүртгэлд үндэслэн гаргахдаа Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг олгох журмын 1.2-д Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2.5 жил, техникийн боловсролын 1.5 болон 3 жилийн сургалтад хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчдид тэтгэлэг олгоно гэж заасныг мөрдлөг болгон регистрийн дугаараар хяналт хийж 24-ээс дээш насны суралцагчдад тэтгэлэг олгодог байдлыг зогсоох.
3. Хөдөлмөрийн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/197 тоот тушаалаар батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журмын 3.2-д Мэргэжлийн боловсрол олгох сургалтад суурь боловсролтой иргэнийг элсүүлнэ гэж заасныг мөрдөж ажиллан суурь боловсролын гэрчилгээгүй, ерөнхий боловсролын сургуулийн албан бус боловсролд бүртгэлтэй суралцагчийг давхар бүртгэн суралцуулж байгаа байдлыг зогсоох.
4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд хамаарна гэж заасны дагуу Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ шилэн дансны цахим сүлжээнд холбогдож хуулинд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж ажиллах.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ХАРЬЯА "ЭРДЭНЭ" МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

Монгол улс, Төв аймаг, Эрдэнэ сум, 5-р баг
Утас: 89856561, 99745515
Э-шуудан: www.erdenekhia@yahoo.com

2015.10.09 № 04/03

Танай _____ № _____

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

МБСДСангаас тус "Эрдэнэ" МСУТ-ийн суралцагсадын тэтгэлэг олголтод холбогдох хууль журмын дагуу аудит хийсэн. Аудитаар гарсан зөрчил дутагдалдаа дүгнэлт хийж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

ХҮНДЭТГЭСЭН:

ЗАХИРАЛ  Д.БАЙГАЛМАА



Товч А5



**ЗААМАР СУМ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

213318 Төв аймаг Заамар сум
Бат-өлзийт Утас: 3142 Факс: 012758-3142

2016.10.10 № 02/96
таний _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төв аймгийн аудитын газраас хийсэн нийцлийн
аудитын дүгнэлт зөвлөмжтэй танилцлаа.Өгсөн
зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Захирлын үүргийг дүр орлон
гүйцэтгэгч  Э.Цэхиад



My Doc Tool A-5



**“МАЙНДСЕТ”
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРТЭЛИЙН ТӨВ**

41120, Төв аймаг, Батсүмбэр сум,
Мандал 1-р баг, Үйлдвэрийн 1-4а
Утас: (976)-99058594
Вэб хуудас: www.mindset-edu.org

2016. 10.10 № 36

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Манай төв танай байгууллагын хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Бидний зүгээс энэхүү дүгнэлтэд нэмэлт тайлбар байхгүй байна.

Цаашид өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.



ЗАХИРАЛ

Б.ГАЛБАДРАХ



**ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМАН ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

Төв аймаг, Баянчандмань сум, Чандмань бэлт,
Утас: 94277446, 88002308 Факс: 70276336
И-мэйл: boolo0812@yahoo.com
Вэб сайт: www.bayanchandmani.edu.mn

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

2016.10.10 № 118
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Ангийн журналын ирцийн бүртгэл хөтлөлтөнд анги удирдсан багш, арга зүйч, сургалтын менежерийн үйл ажиллагааг идэвхижүүлэн тогтмол тавих хяналтыг сайжруулан ажиллана.

Мэргэжлийн Боловсрол сургалтанд суралцаж мэргэжилтэй болох сонирхолтой амьжиргааны баталгаажих түвшин доогуур, сургууль завсардсан, хөдөлмөр эрхлэх насны залуучууд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаагаар их байдаг. Хөдөлмөрийн салбарын үйл ажиллагааны үндсэн зорилт, МСҮТөвийн захирлын үр дүнгийн гэрээнд "ажилтай орлоготой монгол хүн" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилгүй хөдөлмөр эрхлэх насны залуучуудыг МСҮТөвөөр дамжуулан нас харгалзахгүйгээр суралцуулж мэргэжил олгон, ажлын байранд зуучилсан. Бид амьдралаас хөндий хууль ярьж зааглалгүй эдгээр залуучуудыг мэргэжилтэй болгож амьдралд нь хүргэхийн тулд сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцэж сургуулийн дотоод журамд тусган тэтгэлэг олгосон байдаг.

"Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын тэтгэлэг олгох журмын 1.2-д заасны дагуу 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгоно" гэсэн заалт нь салбарын үйл ажиллагаа, МСҮТөвийн үйл ажиллагаатай уялдахгүй хөдөлмөрийн насны залуучуудыг бэлтгэх, ажил олгогчдын ажлын байрны шаардлагатай зөрчилдөж байгаа юм.

Цаашид хуулийн хэрэгжилтэнд хамтран ажиллаж бидний саналыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж өгнө үү.

ЗАХИРАЛ



Э.АМАРТҮВШИН

02 439



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХАРЪЯА
ТӨВ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

41100 Зуунмод, Төв аймаг

Утас: 70273803, Факс:

2016.10.10 № 01/238

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллага нь тусгай санд хийсэн аудитын шалгалтын тайлангын дүн дүгнэлттэй уншиж танилцлаа. Тухайн шалгалтын үр дүнд өгсөн зөвлөмжийг цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, засан сайжруулах талаар ажлын төлөвлөгөө гарган ажиллах болно. Шаардлагын дагуу зохих багш, албан тушаалтанд сургуулийн дотоод дүрэм, журамд заасны дагуу арга хэмжээ авахыг мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ



Б.АЛТАНЗУЛ

My com/D/2016/ A5 toot

00000376